

Байгууллагын нэр: Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар

Тайлан болосвуулсан албан хаагч: Б.Сайнбаяр

Холбоо барих мэдээлэл

Утас: 70140423

имэйл хаяг: sainbayarbs@gmail.com

Тайлан өгсөн огноо: 2017.12.04

2017 ОНЫ ГАДААД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

I. Гадаад томилолт

Д/д	Улс, хот	Албан тушаал	Хүний тоо	Хугацаа	Зорилго	Төсөв	Үр дүн
1	БНХАУ, ХӨХ ХОТ	Газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Д.Зандармаа, С.Гочоосүрэн	2	2017.03.23–29	“Хүлэмжийн аж ахуйтай танилцах” сэдэвт 7 хоногийн сургалтанд хамрагдсан.	Швейцарын хөгжлийн агентлаг	<p>Монгол ногоо” төсөл “ Фермер эмэгтэйчүүдийн холбоо” ТББ хамтран “Монгол ногоо” төслийн гуравдугаар бүрэлдэхүүн хэсэг болох “Хотын болон хот орчмын эмзэг бүлгийн өрхийн хүнсний ногооны үйлдвэрлэл, хэрэглээг өрхийн хүнсний ногооны тариалалтаар нэмэгдүүлэх” дэд төслийн хүрээнд төсөлд хамрагдсан иргэд болон ХААИСургуулийн багш нар, мэргэжилтэнүүд болон агрономичид нийт 18 хүн хамрагдлаа.</p> <p>Энэхүү сургалт нь БНХАУ-ын Хөх хотын жимс жимсгэнэ, хүнсний ногоо салбарын арга туршлагыг хөгжиж буй орнуудад нэвтрүүлэхэд ихээхэн үр дүнгээ өгсөн сургалт болж чадсан ба тус улсын сүүлийн үеийн техник технологийн дэвшилтэд аргыг газар дээр нь үзэж танилцсанаараа онцлогтой. Тус сургалтаар сурсан мэдлэгээ өөрийн орны байгаль цаг уурын онцлогт тохируулан нэвтрүүлж ажиллах, хүнсний ногооны тариалалтын хугацаанд химийн болон органик бордооны зөв зохистой хэрэглээг газар тариалан эрхлэгчдэд дамжуулах, газар тариалан эрхлэгчдийн бага оврын тоног төхөөрөмж болон ногооны үр худалдан авах боломжыг судлах, мэргэжилтэн урьж ажиллуулах замаар үнэтэй зөвлөгөө авах зэрэг олон ажлыг хийх санаа сэдэл болсон сургалт болсон.</p>
2	БНСУ, СӨҮЛ ХОТ	Газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Авирмэд, Б.Шатарбал	2	2017.04.16-22	Хүнсний бөөний худалдааны цэг байгуулах, гарах захын үйл ажилгаатай танилцах сургалт	НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага	<p>Хонгдонг-мун дахь органик фермээр зочилж органик тариалангийн тариалалтыг хэрхэн хийж байгаа байдал, мужийн иргэд хоршооны зохион байгуулалтанд орж хамтын хөдөлмөрийн давуу талыг мэдэрч өөрсдийн амьжиргаагаа дээшлүүлж байна. Мөн ногооны хоршоод нь тариаланчаас органик бүтээгдэхүүнийг шууд худалдан авч цаашаа борлуулалтанд өгч тухайн бүс нутгийн тариаланчдыг бүрэн дэмжиж шинэ залуу тариаланчдыг бэлтгэж байна. Гишүүд нь хоршоо болон дундын хоршооны хугацаандаа борлуулалт хийгддэг сайн талуудыг дурдаж байна. Дундын хоршоо нь том агуулах, сургалт явуулах замаар өөрийн гишүүдийн тариалсан ногоог зах зээлд борлуулах, чадамжуулан ажиллаж байна. 15 гаруй нэр төрлийн ногоог өглөө бүр шинэ байдлаар хүлээн авч борлуулалтаа хийх, мөн сав баглаа боодлыг шошгожуулан зах зээлдээ нийлүүлдэг байна.</p> <p>Органик бордооны үйлдвэртэй танилцлаа.Энэ үйлдвэр нь мөн л хоршоологчдын мэдэлд үйл ажиллагаагаа явуулж үйлдвэрлэсэн бордоог хоршооны бүх гишүүд худалдан авч тариалалтандаа ашигладаг зарчмаар ажиллаж байна.</p> <p>Фермерчдийн захтай танилцах “Гарак” захын үйл ажиллагаа, менежменттэй сургалтын хэлбэрээр 2 өдөр, 2 өдөр дуудлагын худалдаа хийж байгаа байдал, шөнийн болон үүрийн худалдааг хэрхэн зохион байгуулж байгаатай танилцсан.</p> <p>Хяналт шинжилгээ, аюулгүй байдлыг хангах төвийн үйл ажилгаатай танилцлаа. Тус төв нь өглөө бүр эхаад ирж худалдаалагдаж байгаа бүх ногооны дээжийн авч 15-20 минутанд шаардлагатай бүх нөхцлөөр шинжилгээг хийж дүгнэлтийг гарган өгдөг өндөр хүчин чадаотай төв ажиладаг байна. Мөн цэцэрлэг,сургуулийн хүүхдийн хүнсний асуудлыг онцгой анхаарч маш өндөр зэрэглэлийн эрүүл ахуйн орчинд хурааж ,тээвэрлэлт хийж хүргэдэг үйлчилгээтэй юм байна.УБ хотод хүнсний ногооны үйлдвэр эрхлэгчдийг энэ үйлдвэр дэмжих боломжийг судлаж харахад үнэтэй аж холбогдолтой.</p>
3	БНСУ, БУСАН ХОТ	Газар тариалангийн хэлтсийн дарга Ц.Төмөртулга, Эрчимжсэн мал аж ахуйн мэргэжилтэн Б.Гантулга	2	2017.04.16-23	Хотын хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдэд зориулсан сургалт	Бусан хотын хамтын ажиллагааны сан	<p>Бүгд найрамдах Солонгос улсын Бусан хотын олон улсын сургалтын хөтөлбөрийн хүрээнд Хот, суурин газрын хөдөө аж ахуй, хөдөө аж ахуйн орчны хөгжүүлэлт сэдэвт сургалтад хамрагдлаа.</p> <p>Солонгос улсын орон нутгийг хөгжүүлэх болон хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого болоод хөдөө аж ахуйгаас үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээг бий болгох, Байгаль орчинд ээлтэй хөдөө аж ахуйг бий болгох тухай болон Улаан лооль, гүзээлзгэнэ, цэцгийн аж ахуй, Хөдөө аж ахуйн техник дундын төв болон хөдөө аж ахуйн машин хэрэгслийг түрээслэх төвтэй танилцав. Монголд нэвтрүүлэх боломжийг судалж байна.</p>

4	БНХАУ, БЭЭЖИН ХОТ	Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Р.Ундармаа	1	2017.05.03-23	"Ази-Европын орнуудын хүнсний аюулгүй байдлын удирдлага" олон улсын богино хугацааны сургалт	БНХАУ-ын Худалдааны яам, Хүнсний болон исгэлтийн үйлдвэрлэл судлалын сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн	Монгол Улсаас ХХААХҮЯ, Нийслэлийн болон Дорнод, Орхон, Говь-Алтай аймгийн ХХААГ, Нийслэлийн мал эмнэлгийн газар, УМЭАЦТЛ болон Говьсүмбэр аймгийн МХГ-аас нийт 10 төлөөлөгч, БН Гүрж улсаас ХААЯ, Спорт, залуучуудын яам, ХААИС, Техникийн их сургуулийн төлөөлөл 10, БН Турк Улсын ХААЯ болон Гааль, худалдааны яамны төлөөлөл 10, Тайландын Вант улсын ХААИС, Технологийн их сургууль, Анагаах ухааны их сургуулийн төлөөлөл 10, БН Камбож Улсын ХААОЗЯ болон орон нутгийн хөдөө аж ахуйн газрын 10, Палестин улсын Аюулгүй байдлын хорооны төлөөлөл 2 буюу нийт 52 оролцогч хамрагдав. Хятадын хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан холбогдох байгууллага, хүрээлэн, их сургуулиас багш, докторууд танхимын сургалт хийв. Сургалтаар БНХАУ-ын Хүнсний аюулгүй байдлын асуудлууд, холбогдох байгууллагуудын үүрэг хариуцлага, Хүнс, эмийн захиргааг байгуулах шаардлага, байгуулсан туршлага, 2015 онд шинэчлэн батлуулсан Хүнсний тухай хууль болон холбогдох журам, стандартад гарсан өөрчлөлтүүд, тэдгээрийн үр дагавар болон үйлдвэрлэлд хэрхэн нэвтрүүлж байгаа талаарх туршлагаасаа Хятадын хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан холбогдох байгууллага, хүрээлэн, их сургуулиас багш, докторууд, хүнс үйлдвэрлэгч томоохон үйлдвэрийн жишээн дээр тайлбарлан танилцууллаа. Мөн БНХАУ-ын Шандун мужийн Чингдао хот, Жиансу мужийн Шүэзоу хотод хүнсний үйлдвэрүүдтэй танилцах аялалыг 5-р сарын 9-19-ний өдрүүдэд зохион байгуулсан.
5	БНХАУ, ЯНЛИН ХОТ	Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн Ч.Батхүү Ч.Чулуунцэцэг	2	2017.05.19-06.08	"Хөгжиж буй орнуудын үхрийн махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон сүүний үйлдвэрлэлийн технологий" сургалт	БНХАУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яам, Янлин хотын Олон улсын солилцооны төв, Янлин хотын Мэргэжлийн болон техникийн коллеж	Үхрийн мах, сүүний чиглэлийн үнээний үүлдэр, хоол тэжээл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн менежмент, хонь, үхрийн фермийн аж ахуй эрхлэх бүс, түүнд тавигдах стандарт, мал амьтны өвчин, түүний тархалт, хүнсний үйлдвэрлэлийн хяналт, сүүний фермийн технологи, эрчимжсэн фермийн хүрээлэн буй орчны хяналт зэрэг 14 чиглэлийн сэдэв бүхий 112 цагийн танхимын сургалтад хамрагдсан. Янлин хотын Мэргэжлийн болон техникийн коллежийн шинжилгээний лаборатор. Хөдөө Аж Ахуйн Модерн Парк, үхрийн махны үйлдвэр Кинг Булл ХХК-ны үйл ажиллагаатай биечлэн танилцаж, туршлага солилцлоо. Мөн Шиап хотноо Хятад улсын Хөдөө аж ахуйн өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын талаарх онол практикийн хурал, Янлин хотноо Хөдөө аж ахуйн хөгжлийн форумд тус тус оролцсон. БНХАУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны санхүүжилтээр Янлин хотын Олон улсын солилцооны төвөөс зохион байгуулсан тус сургалт нь хөгжиж буй орнуудын хөдөө аж ахуйн салбарын удирдлагууд, мэргэжилтэн албан хаагч, үйлдвэрлэл эрхлэгч нарт үр өгөөжтэй, онол, практик хосолсон сургалт болж өндөрлөлөө.
6	БНХАУ, БЭЭЖИН, ХАРБИН, ЖИЛИН ХОТ	Эрчимжсэн мал аж ахуйн мэргэжилтэн Ц.Ариунзүл	1	2017.08.18—09.05	Хотын хөдөө аж ахуйн мэргэжилтэнүүдэд зориулсан сургалт	Монгол, Хятадын хамтын ажиллагааны сан	Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны хамгаалал" сэдэвт сургалтын хүрээнд: - Хятадын хөдөө аж ахуйн газар нутгийн хөрс, түүний ашиглалт, хамгаалалт, сайжруулалт - Хятад дахь ургамлын үйлдвэрлэл, хамгаалагдсан цэцэрлэгжүүлэлтийн хөгжил - Хятадын хөдөө аж ахуйн бодлого, төлөвлөлт - Хятад дахь хөдөө орон нутгийн шинэчлэлт, хөдөө аж ахуйн хөгжил - Хятадын энгийн түүхэн үе шатууд зэрэг лекц, семинари, ХАА-н хотуудтай танилцлаа. Мөн Хэйлонгжиан /Харбин/ болон Жилин мужийн хотуудад ХАА-н органик газар тариалангийн хөгжил, усан болон ойн аж ахуйн паркуудтай танилцлаа. Харбин нь усан паркаараа алдартай мөн Жилин хот нь ойн паркаар алдартай бөгөөд ойн аж ахуйн хөгжлийн түүх, дурсгалт газруудыг болон Жилин хотод шинээр байгуулагдаж буй шинэ төсөл болох хүнсний үйлдвэрлэлийн бүс нутгийн хөгжилтэй танилцлаа. Төсөл хэрэгжүүлэгч хамтран ажиллах талууд Хятад, Сингапур, Өмнөд Африкийн орнууд нийт 100 гаруй орнуудын эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжилтнүүдийн судалгаан дээр үндэслэсэн маш өргөн хүрээний төслийн үйл ажиллагааны танилцууллага, тухайн бүсэд шинэ хот байгуулж зөвхөн хүнс үйлдвэрлэлийн процессийн эхний шатаас эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж хэрэглэгчдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, хүнсний хангамж, аюулгүй байдлыг хянах хяналтын системийг бүрэн нэвтрүүлсэн төслийн үйл ажиллагааны явц, бүтээн байгуулалттай танилцсан үр дүнтэй, сонирхолтой сургалт байлаа.

7	БНХАУ, ХӨХ ХОТ	Газрын дарга Д.Баянбат Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга А.Цэцгээ	2	2017.09.26-30	"Монгол-Хятадын экспо" хоёр дахь удаагийн арга хэмжээ	Нийслэлийн Засаг даргын хамт айлчлал	<p>"Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал"-ын хүрээнд 2 улсын анхны экспо 2015 онд Хөх хотод амжилттай зохион байгуулагдсан бөгөөд энэ удаагийн экспо улам өргөжиж, Монгол Улсаас төр, хувийн хэвшлийн 1600 гаруй төлөөлөгчид оролцсон.</p> <p>Нийслэлийн төлөөлөгчид экспо арга хэмжээнд оролцсоноос гадна Хөх хотын орлогч дарга Цай Уйдун, Кан Цүнъяо нартай албны уулзалт хийж, Хөх хотын холбогдох байгууллагуудын удирдлагуудтай албан дарга Цай Уйдун, Кан Цүнъяо нартай албан уулзалт хийж, холбогдох байгууллагын удирдлагуудтай хамтын ажиллагааны чиглэлээр харилцан санал солилцож, Мэн Ню, Монгол өвс зэрэг компанийн үйл ажиллагаатай танилцсан нь хоёр хотын харилцааг өргөжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Албан уулзалтын дараа нийслэлийн төлөөлөгчид Хөх хотын орлогч дарга Кан Цүнъяо тэргүүтэй тус хотын хөдөө аж ахуй, эдийн засаг, үйлдвэрлэл, хот тохижилт зэрэг байгууллагын удирдлагуудтай уулзаж, талууд өөрсдийн байгууллагын талаар товч танилцуулга хийж, харилцан санал солилцов. Уулзалтын үр дүнд талууд цаашид дараах чиглэлээр хамтарч ажиллахаар санал дэвшүүлэв. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчид, мэргэжилтнүүдийг тус хотын хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн тэргүүний техник, технологи, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан зэрэг чиглэлээр туршлага судлуулж, хамтарч ажиллах, 2. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ирэх онд хоёр хотын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, нийслэлийн төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хөрөнгө оруулалтын хамтарсан чуулга, уулзалтыг хамтран зохион байгуулах, 3. Нийслэлийн Үйлдвэрлэл, инновацийн газар Хөх хотын үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаатай танилцаж, Багануур, Налайх, Эмээлтийн үйлдвэрлэл технологийн парк байгуулахад тус хотоос туршлага судалж, хамтарч ажиллах, 4. Нийслэлийн Авто замын хөгжлийн газар нь BRT болон метроны төслийг хэрэгжүүлэхэд аль нь илүү замын түгжрэлийг бууруулахад ач холбогдолтой талаар Хөх хотын холбогдох байгууллагатай санал солилцож, цаашид хамтарч ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлэв.
8	БНСУ, ГИОНСАНБУГ ХОТ	Газрын дарга Д.Баянбат, Газар тариалангийн хэлтсийн дарга Ц.Төмөртулга, Газар тариалангийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Төмөртоого	3	2017.11.13-18	БНСУ-ын Гёнсанбуг аймаг, Кионгпук олон улсын сургалт, судалгаа, хөгжлийн үндэсний Институттай байгуулсан хамтран ажиллах "Санамж бичиг"-г тусгасан хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, нийслэлийн хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт татах зорилготой	БНСУ-ын Кионгпук олон улсын сургалт, судалгаа, хөгжлийн үндэсний институт	<p>БНСУ-ын Кионгпук их сургуулийн урилгаар Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Д.Баянбатаар ахлуулсан 11 төлөөлөгч оролцлоо. БНСУ-ын төрөөс газар тариалан эрхлэгчдээ дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд, Гёнсанбуг аймгийн хөдөө аж ахуйн салбарын эрчимтэй хөгжилтэй танилцаж, туршлага судаллаа. Туршлага судлах айлчлалын хүрээнд үзэж танилцсан үйл ажиллагаануудаас шинэ тосгон хөдөлгөөн, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, смарт хүлэмжийн аж ахуй, үйлдвэрлэлийн бүхий л салбарт автоматжуулалтыг нэвтрүүлсэн байдалтай танилцсан нь нэн чухал байлаа. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийн ажлыг хөнгөвчлөх, зардлыг хэмнэх, бүтээгдэхүүний өртгийг бууруулах зорилгоор төрөөс орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байгуулан хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байгаа нь хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, ажиллах хүч багатай манай улсын хувьд нэвтрүүлүүштэй санаа байлаа.</p> <p>Мөн Гёнсанбуг аймаг, Исон-Гүн хот болон Кионгпук их сургуулийн удирдлагуудтай уулзаж хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдал, төрөөс баримталж буй бодлогын талаар мэдээлэл авч цаашид Монгол улстай хамтын ажиллагаагаа хэрхэн өргөжүүлэх талаар санал солилцлоо.</p> <p>Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, БНСУ-ын Кионгпоок сургалт, судалгааны институтын хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулагдсан ба энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын хөдөө аж ахуйн салбарт доорх чиглэлээр хамтарч ажиллах саналыг газрын дарга Д.Баянбат тавилаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хотод "ХАА-н сургалт үйлдвэрлэлийн төв" байгуулах, үүгээр дамжуулан иргэдэд тоног төхөөрөмжийн түрээсийн болон засварын үйлчилгээ үзүүлэх, шинэ төрлийн тарималуудыг туршиж, нутагшуулах, тариалах, хөрсний үржил шимийг сайжруулахад чиглэсэн төсө хөтөлбөр хэрэгжүүлэх - Гёнсанбуг аймгийн захиргаатай хамтран хөдөө аж ахуйн чиглэлээр төрийн байгууллагын ажилчдыг туршлага судлуулах, ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн дадлагажуулах, мэргэжил дээшлүүлэх урт хугацааны сургалтанд хамруулах, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх - БНСУ-аас ХАА-н чиглэлийн мэргэжилтэн урьж ажиллуулах - Улаанбаатар хотод хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хадгалалт, борлуулалтын сүлжээг сайжруулахад тусламж дэмжлэг авах - Улаанбаатар хотод өвлийн хүлэмжийн аж ахуйн байгуулахад төр, хувийн хэвшлүүдтэй хамтарч ажиллах - "Загвар фермерийн аж ахуй" байгуулахад хөрөнгө оруулалтын дэмжлэг авах - Хотын агаарын бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч ажиллах зэрэг саналуудыг тавилаа.

9	БНСУ, БУСАН ХОТ	Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга А.Цэцгээ	1	2017.11.02-18	"Азийн хөгжиж буй орнуудын хүнсний аюулгүй байдал хариуцсан албан хаагчдын чадавхийг бэхүүлэх" сэдэвт сургалт	БНСУ-ын КОИСА -гийн Глобал сургалтын хөтөлбөр, КОИСА олон улсын холбооны төв	Солонгос улсын хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан холбогдох байгууллага, хүрээлэн, их сургуулиас багш, докторууд танхимын сургалт хийв. Сургалтаар БНСУ-ын Хүнсний аюулгүй байдлын асуудлууд, холбогдох байгууллагуудын үүрэг хариуцлага, Хүнс, эмийн захиргааг байгуулах шаардлага, байгуулсан туршлага, 2000 оноос хойш шинэчлэн батлуулсан Хүнсний тухай хууль болон холбогдох журам, стандартад гарсан өөрчлөлтүүд, тэдгээрийн үр дагавар болон үйлдвэрлэлд хэрхэн нэвтрүүлж байгаа талаарх туршлагаасаа Солонгосын хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан холбогдох байгууллага, хүрээлэн, их сургуулиас багш, докторууд, хүнс үйлдвэрлэгч томоохон үйлдвэрийн жишээн дээр тайлбарлан танилцууллаа. Мөн БНСУ-ын Тэжон хотын Кимчины үйлдвэр, Самсунг корпорацийн дэвшилтэт техник технологийн үйл ажиллагаатай танилцлаа. Бусан хотын сүүний үйлдвэр, цагаан будаагаар бүх төрлийн бэлэн хоол үйлдвэрлэж GS-25 сүлжээ дэлгүүрүүдийг хангадаг хүнсний үйлдвэрүүдтэй танилцав.
II. Зочид төлөөлөгчид							
1	ЯПОН, МИЯКОНОЖО ХОТ	Иший Ёшихироо	1	2017.11.28	Хотуудын хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагаа	Байхгүй	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Д.Баянбат Мияконожо хотын Хөдөө аж ахуйн хэлтсийн дарга Иший Ёшихироог өнөөдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтад нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дэд дарга Д.Пүрэвсүрэн, Захиргааны хэлтсийн дарга Д.Мягмарсүрэн, Газар тариалангийн хэлтсийн дарга Ц.Төмөртулга, Хүнсний үйлдвэрлэлийн хэлтсийн дарга А.Цэцгээ, Мияконожо хотын Хөдөө, аж ахуйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн Нишихита Юйичи, Хөдөө, аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн Мацубара Шинья болон бусад албаныхан байлцав. Уулзалтын үеэр Мияконожо хотын Хөдөө аж ахуйн хэлтсийн дарга Иший Ёшихироо Мияконожо хотын Захирагч Икэда Такахисагаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид хаягласан мэндчилгээг уламжиллаа. Тэрбээр "Энэхүү захидалд хоёр хотын найрамдалт харилцаа мандан бадарч, цэцэглэн хөгжихийг бэлэгшээсэн гэдгийг энд онцлон хэлмээр байна. Мияконожо хот өөрийн брэнд үхрийн махыг гадаадын зах зээлд гаргах ажлын хүрээнд Япон улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас зохион байгуулдаг Эзэн хааны төрсөн өдрийн хүндэтгэлийн хүлээн авалтад мияконожо брэнд үхрийн махаар хийсэн зоог танилцуулан сурталчлах юм. Бид бүхэн тус арга хэмжээнд оролцох зорилгоор энэ сарын 27-ноос ирэх сарын 1-ний өдрүүдэд Улаанбаатар хотод айлчилна" гэв. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Д.Баянбат "Бид бүхэн хоёр хотын хөдөө аж ахуйн салбарыг өргөжүүлэх гол зорилготой хүмүүс. Тиймээс та бүхэнтэй эл салбарт хамтын ажиллагааг өрнүүлэх талаар цаашид хамтран ажиллахдаа таатай байх болно. Хоёр хотын хамтын ажиллагаа цаашид салбар бүрт олон санал, санаачлагын дагуу өргөжинө гэдэгт итгэлтэй байна" хэмээлээ.
III. Гадаад арга хэмжээ							
1							
IV. Гэрээ, Санамж бичиг							
Д/д	Улс, хот	Гадны байгууллагын нэр, албан тушаал	Төрөл	Огноо	Тэргүү	Гарын үсэг зурсан байгууллагын нэр, албан тушаал	Зорилго/Үр дүн
1	БНСУ	БНСУ-ын Кионгпоок олон улсын сургалт судалгааны Институтын захирал Професор. Dong Hyun Sin	СБ	2017.09.18	Хамтран ажиллах тухай	НХХААГ-ын дарга Д.Баянбат	Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр мэдлэг, туршлага солилцох, хамтарсан сургалт, судалгааны ажил хийх Монгол дахь хөдөө аж ахуйн салбарт сургалт, хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх Монголын хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн 6 дахь хөгжлийн санал санаачилгыг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах Салбарын чиглэлээр нийтлэл, тайлан, бусад эрдэм шинжилгээний мэдээ, мэдээлэл солилцох Харилцан тохиролцсон бусад чиглэлээр хамтарч ажиллах
2	БНСУ	Жи эй им сургалтын төв	СБ	2017.11.1	Хамтран ажиллах тухай	НХХААГ-ын дарга Д.Баянбат	Хүнсний ногооны шинэ сортын таримлын нэр төрлийн нэмэгдүүлэх, гоел чимэглэлийн цэцэг, хүлэмжийн тариалалт, техник технологи, эрчимжсэн мал аж ахуй болон гахай шувууны аж ахуйг хөгжүүлэх, туршлага судлах, мэргэжилтнүүдийг чадавхижуулах, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад экологийн боловсрол олгох сургалт, семинарыг зохион байгуулах талаар санал солилцон, хамтран ажиллах